




Цагаантолгой ХК

Үйл ажиллагааны тайлан

2021



1. Компаний танилцуулга

Цагаантолгой ХК нь газар тариалан, мал аж ахуй, зочид буудал, зоогийн газрын үйлчилгээ, гурилын үйлдвэрлэл, хүнсний төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдааны үйл ажиллагаа эрхлэн явуулах зорилгоор 1995 онд анх үүсгэн байгуулагдсан ба голлох хувьцаа эзэмшигчидийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбоотойгоор 2013 оны улсын бүртгэлийн хуулийн этгээдийн нэгдсэн тооллогод бүртгүүлж 11,081.3 мянган төгрөгийн хөрөнгө оруулалттайгаар үйл ажиллагаа явуулж байна. Компаний хуучин эрхэлж байсан үйл ажиллагаанаас гадна бизнесийн консалтинг, гадаад худалдааны чиглэлээр түлхүү үйл ажиллагаа эрхлэх зорилгоор тодорхой бизнес төслүүдийг эхлэхээр төлөлөж байгаа боловч Монгол улсын гадаад хөрөнгө оруулалтын орчин, эдийн засгийн нөхцөл байдал, дэлхий дахинд дэгдээд буй цар тахалтай холбоотойгоор түр хугацаанд хойшлуулсан байдалтай байна.

2. Хаяг:

Сэлэнгэ аймаг Сант, 2-р баг, Хашаат, 1, 1-27 тоот Утас: (+976) – 99788501

3. Үйл ажиллганы тайлан

Компани нь хэдийгээр Монгол улсын гадаад хөрөнгө оруулалтын орчин, эдийн засгийн нөхцөл байдал, дэлхий дахинд дэгдээд буй цар тахалтай холбоотойгоор 2021 онд идэвхитэй үйл ажиллагаа явуулаагүй боловч гадаад худалдаа, бизнес консалтинг-ийн үйлчилгээний чиглэлээр тодорхой судалгааны ажлуудийг хийж гүйцэтгэсэн.

4. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид

1	ЭРДЭНЭБАЯР ЯНЖИНЛХАМ	27.77 %
2	АМГАЛАН ЧИМГЭЭ	55.53 %

5. Ногдол ашиг

Цагаантолгой ХК нь 2021 онд идэвхитэй үйл ажиллагаа явуулаагүй тул 2022 оны 2 сарын 10-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын 1/0 тоот тогтоолоор ногдол ашиг хуваарилахгүй шийдвэр гаргасан болно.

6. Санхүүгийн мэдээлэл

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“ЦАГААН ТОЛГОЙ” ХК-ийн Хувьцаа Эзэмшигчдэд:**Аудитын дүгнэлт**

Бид “Цагаан толгой” ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг болох санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр “Цагаан толгой” ХК-ийн санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан нь материаллаг байдлын хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчдээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуу ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудлууд нь бидний мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайланд хийсэн бидний аудитад хамгийн их анхаарал татсан асуудал байдаг. Бид харилцахуйц хэмжээний аудитын гол асуудал байхгүй гэж тодорхойлж байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь компанийн жилийн тайланд орсон боловч санхүүгийн тайлан болон аудиторын тайланд ороогүй мэдээллээс бүрдэнэ. Бидний компанийн санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй.

Компанийн Удирдлагын хүлээх хариуцлага

Компанийн удирдлага нь СТОУС-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй компанийн санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудыг тодорхойлно.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)**Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага**

Бидний зорилго бол компанийн санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид дараах ажлуудыг хийсэн:

- ✓ Санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.
- ✓ Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- ✓ Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- ✓ Санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг “Цагаан толгой” ХК-ийн Удирдах зөвлөлд зориулан бэлтгэсэн ба бид тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



Д.Түмэнжаргал Ерөнхий захирал
МОНГОЛИАН БИЗНЕС РЕЙТИНГ АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ УЛС

2022 ОНЫ 03 ДУГААР
САРЫН 05-НЫ ӨДӨР

“ЦАГААН ТОЛГОЙ” ХК-ИЙН

2021 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлан

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жил

Үзүүлэлт	Тодруулга	2020.12.31 (мян.төг)	2021.12.31 (мян.төг)
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4.1	89.0	159.5
Дансны авлага	4.2	150.0	150.0
Эргэлтийн хөрөнгийн дүн		239.0	309.5
Эргэлтийн бус хөрөнгө	4.3	11,081.3	11,081.3
Үндсэн хөрөнгө			
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		11,081.3	11,081.3
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		11,320.3	11,390.8
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
ӨР ТӨЛБӨР			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны өглөг	4.4	23,151.4	49,651.8
Татварын өр	4.5	289.0	447.3
НДШ - ийн өглөг	4.5	364.0	324.6
Богино хугацаат өр төлбөрийн дүн		23,804.4	50,450.7
Урт хугацаат өр төлбөрийн дүн		-	-
Өр төлбөрийн нийт дүн		23,804.4	50,450.7
Эздийн өмч			
Өмч		11,081.3	11,081.3
-хувийн	4.6	11,081.3	11,081.3
Хуримтлагдсан ашиг	4.6	-23,565.4	-50,141.2
Эздийн өмчийн дүн		-12,484.1	-39,059.9
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		11,320.3	11,390.8

Эдгээр санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамтаар уншина уу.

“ЦАГААН ТОЛГОЙ” ХК-ИЙН

2021 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлан

АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жил

Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх он (мян.төг)	Тайлант он (мян.төг)
Борлуулалтын орлого (цэвэр)	-	-	-
Борлуулалтын өртөг	-	-	-
Нийт ашиг (алдагдал)	-	-	-
Бусад орлого	-	-	-
Борлуулалт, маркетингийн зардал	-	-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	4.7	11,205.6	26,575.8
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-	-11,205.6	-26,575.8
Орлогын татварын зардал	-	-	-
Татварын дараах ашиг (алдагдал)	-	-11,205.6	-26,575.8
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-11,205.6	-26,575.8
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
Орлогын нийт дүн	-	-11,205.6	-26,575.8
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-	-

Эдгээр санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамтаар уншина уу.

“ЦАГААН ТОЛГОЙ” ХК-ИЙН

2021 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлан

АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жил

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн (мян.төг)
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	11081.3	-	-	-12,359.8	-1,278.5
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	11081.3	-	-	-12,359.8	-1,278.5
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-11,205.6	-11,205.6
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	11081.3	-	-	-23,565.4	-12,484.1
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	11081.3	-	-	-23,565.4	-12,484.1
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-26575.8	-26,575.8
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	11081.3	-	-	-50,141.2	-39,059.9

Эдгээр санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамтаар уншина уу.

“ЦАГААН ТОЛГОЙ” ХК-ИЙН

2021 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлан

АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жил

Үзүүлэлт	Өмнөх он (мян.төг)	Тайланг он (мян.төг)
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
<u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	-	-
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	-
Бусад мөнгөн орлого	-	-
<u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>	10,552.5	26,429.5
Ажиллагчдад төлсөн	9,922.1	12,927.6
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	630.4	3,627.0
Бараа материал худалдан авахад төлсөн	-	-
Татварын байгууллагад төлсөн	-	771.0
Бусад мөнгөн зарлага	-	9,103.9
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-10,552.5	-26,429.5
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
<u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	-	-
<u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
<u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	9,249.5	26,500.0
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	9,249.5	26,500.0
<u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	9,249.5	26,500.0
Валютын ханшийн зөрүү	-	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-1,303.0	70.5
МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	1,392.0	89.0
МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	89.0	159.5

Эдгээр санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамтаар уншина уу.